



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2022 оны 10 дугаар сарын 21
№ 41 (1239)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

762.	Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 58	3022
763.	Түр хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	Дугаар 59	3024

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

764.	Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 129	3028
765.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 132	3028
766.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 133	3029

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

767.	Аргачлал батлах тухай	Дугаар 202	3029
------	-----------------------	------------	------

ТЭГШ

70000	70000 70000 70000 70000 70000 70000 70000 70000	70000 70000 70000 70000 70000 70000 70000 70000	70000 70000 70000 70000 70000 70000 70000 70000
-------	--	--	--



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 10 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 58

Улаанбаатар
хот

Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин, Төмөртоогогийн Энхтүвшин нарыг Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны, Монгол Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны, Монгол Улсын Их Хурлын гишүүн Хаянгаагийн Болорчулууныг Эдийн засгийн байнгын хорооны, Монгол Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрамыг Нийгмийн бодлогын байнгын хорооны, Монгол Улсын Их Хурлын гишүүн Баттогтохын Чойжилсүрэнг Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

2. Монгол Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшинг Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны, Монгол Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрамыг Эдийн засгийн байнгын хорооны, Монгол Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбатыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

3. Энэ тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 10 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 59

Улаанбаатар
хот

Түр хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэг, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Түр хороог байгуулж, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 31 дүгээр тогтоолын 1 дэх заалтад заасан Түр хорооны бүрэлдэхүүнийг доор дурдсанаар шинэчлэн баталсугай:

Түр хорооны дарга:

Б.Баттөмөр Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй,
сахилга хариуцлагын байнгын хорооны
дарга

Түр хорооны гишүүд:

Б.Энх-Амгалан Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй
байдал, гадаад бодлогын байнгын
хорооны дарга

Б.Саранчимэг Улсын Их Хурлын гишүүн, Байгаль
орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын
хорооны дарга

Г.Мөнхцэцэг Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол,
соёл, шинжлэх ухаан, спортын байнгын
хорооны дарга

Э.Батшугар Улсын Их Хурлын гишүүн, Инновац,
цахим бодлогын байнгын хорооны
дарга



П.Анужин	Улсын Их Хурлын гишүүн, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга
Ж.Мөнхбат	Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга
Г.Тэмүүлэн	Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга
Т.Энхтүвшин	Улсын Их Хурлын гишүүн, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга
Л.Мөнхбаатар	Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга
Ц.Цэрэнпунцаг	Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга
Б.Бейсен	Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн төлөөлөл
С.Ганбаатар	Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь “Та бидний эвсэл”-ийн төлөөлөл
Т.Доржханд	Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь “Зөв хүн электорат эвсэл”-ийн төлөөлөл

2.Энэ тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 07 дугаар
сарын 01-ний өдөр

Дугаар 129

Улаанбаатар
хот

Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 188 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

1.Ягнайжавын Туулыг Дархан-Уул аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

2.Дархан-Уул аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилогдсонтой холбогдуулан Ягнайжавын Туулыг Дархан-Уул аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 132

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 196 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарах эрх үүсэж, өөрөө хүсэлтээ гаргасан Жалцангийн Цэнгэлийг Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 133

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 198 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарах эрх үүсэж, өөрөө хүсэлтээ гаргасан Жамсранжавын Эрдэнэчимэгийг Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 5 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 202

Улаанбаатар
хот

Аргачлал батлах тухай

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12.9-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Нээлттэй өгөгдлийн төлбөр тооцох аргачлал”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ САЙДЫН ҮҮРЭГ
ХАРИУЦАГЧ**

Л.ЭНХ-АМГАЛАН



Засгийн газрын 2022 оны 202 дугаар
тогтоолын хавсралт

НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙН ТӨЛБӨР ТООЦОХ АРГАЧЛАЛ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ аргачлалыг Засгийн газраас баталсан нээлттэй өгөгдлийн жагсаалтад ороогүй, эсхүл нээлттэй өгөгдлийг нийтлэхээс өмнө хүн, хуулийн этгээдийн хүсэлтээр нээлттэй өгөгдлийг боловсруулж өгөх төлбөрийг тооцоход баримтална.

1.2.Энэ журмын 1.1-д заасан төлбөрийн хэмжээг энэ журмын 2.1-д заасан аргачлалд нийцүүлэн мэдээлэл хариуцагч тогтооно.

1.3.Мэдээлэл хариуцагч нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6.1-д заасан этгээд байна.

1.4.Хүн, хуулийн этгээд нь нээлттэй өгөгдлийг цаасан хэлбэрээр авах хүсэлт гаргасан тохиолдолд холбогдох зардлыг нэмж төлнө.

1.5.Энэ аргачлалын 1.4-т заасан зардлын хэмжээг Засгийн газраас баталсан “Хүн, хуулийн этгээдэд цаасан хэлбэрээр нээлттэй өгөгдөл өгөхтэй холбогдон гарах зардал тооцох аргачлал, зардлыг төлөх, түүнээс хөнгөлөх, чөлөөлөх журам”-д заасан аргачлалын дагуу тооцно.

1.6.Нээлттэй өгөгдлийг цахим хэлбэрээр хүн, хуулийн этгээдэд өгөх тохиолдолд энэ журмын 1.4-т заасан зардлыг тооцохгүй.

Хоёр.Нээлттэй өгөгдлийн төлбөр тооцох аргачлал

2.1. Мэдээлэл хариуцагч нь нээлттэй өгөгдлийн төлбөрийг дараах аргачлалын дагуу тооцно:

2.1.1.нээлттэй өгөгдлийг бий болгосон ажилтны ажлын цагийн хөлс, нээлттэй өгөгдлийг боловсруулж гаргахад зарцуулсан гүйцэтгэлийн хугацааг тодорхойлох;

2.1.2.ажлын цагийн хөлсийг тухайн ажилтны 1 өдрийн цалинг ажлын цагийн үргэлжлэх хугацаанд харьцуулсан дүнгээр тооцох бөгөөд дараах томъёог ашиглана:



Ажлын цагийн хөлс = 1 өдрийн цалин/8 цаг (ажлын цагийн үргэлжлэх хугацаа)

Тайлбар: 1 өдрийн цалинг үндсэн цалингаас тооцно.

2.1.3.төлбөрийг тооцож гаргахдаа нээлттэй өгөгдлийг боловсруулж өгөхөд зарцуулах хугацааг ажлын цагийн хөлсөөр үржүүлэх бөгөөд дараах томъёог ашиглана:

Төлбөр = Хугацаа х Ажлын цагийн хөлс

Тайлбар: Хугацаа-Нээлттэй өгөгдлийг боловсруулахад зарцуулсан хугацаа

Гурав.Бусад

3.1.Мэдээлэл хариуцагч нь нээлттэй өгөгдөл боловсруулж өгөхтэй холбоотой төлбөр тооцох аргачлал, түүнийг төлөх данс бүхий мэдээллийг өөрийн цахим хуудас болон тухайн байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан байна.

3.2.Мэдээлэл хариуцагч нь нээлттэй өгөгдөл авсан этгээдээс төлсөн төлбөрийг байгууллагын төсвийн урсгал санхүүжилтийн дансанд төвлөрүүлнэ.

3.3.Мэдээлэл хариуцагч хүн, хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийг үндэслэн нээлттэй өгөгдлийг боловсруулж өгөх хугацаа 30 хоногоос илүүгүй байна.

---o0o---



Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 0.75

Индекс: 200003